

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 10 дугаар сарын 13-ны өдөр

№ 25/44

Улаанбаатар хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”) -ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.23 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2025 оны 10 дугаар сарын 10 -ны өдрийн 25/43 тоот тогтоол, 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн ТУЗ нь 2025 оны 03 сарын 25-ны өдрийн 25/14 тоот “Зээлээр эх үүсвэр татан төвлөрүүлэх, гэрээ байгуулах эрх олгох тухай” болон мөн өдрийн 25/15 тоот “Гэрээ байгуулах эрх олгох тухай” тогтоолуудыг тус тус баталж, “Lendable Asset Management LLC”-ийн төлөөлөлтэй олон улсын хөрөнгө оруулагчид (цаашид хамтад нь “*Санхүүжүүлэгч тал*”)-аас нийт 20 сая ам.доллар хүртэлх хэмжээний зээлийн санхүүжилт (цаашид “*Санхүүжилт*” гэх)-ийг татахтай холбоотой асуудлыг шийдвэрлэсэн болохыг тэмдэглэсүгэй.
2. Улмаар Компани нь АНД ФСЖ Пти.Лтд (цаашид “*Толгой компани*” гэх) болон Санхүүжүүлэгч талтай 2025 оны 04 сарын 07-ны өдрийн Олон талт зээлийн гэрээ (Facilities Agreement), Толгой компанийн зээлийн гэрээ (Parent Company Loan/Facility Agreement)-г, мөн “Lendable Asset Management LLC”-тэй 2025 оны 04 сарын 08-ны өдрийн Хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээ болон эдгээрт дагалдах бусад гэрээнүүд (цаашид “*Гэрээний багц*” гэх)-ийг байгуулсныг тэмдэглэсүгэй.
3. Компани нь Гэрээний багцын дагуу буюу Санхүүжилтийн хүрээнд эхний ээлжинд 10 сая ам.доллар (цаашид “*Эхний санхүүжилт*” гэх)-ыг татан төвлөрүүлж, үйл ажиллагаагаа өргөжүүлэх зорилгоо амжилттай хэрэгжүүлж байгаа тул үлдсэн 10 сая ам.доллар (цаашид “*Хоёр дахь санхүүжилт*” гэх)-ын санхүүжилтийг авахаар бэлтгэн ажиллаж байгааг тэмдэглэсүгэй.
4. Ийнхүү Компани нь Хоёр дахь санхүүжилтийг татан төвлөрүүлэхтэй холбогдуулан Санхүүжүүлэгч талтай хийсэн тохиролцооны дагуу Гэрээний багцад хамаарах гэрээнүүдэд дор дурдсан болон үүгээр хязгаарлагдахгүйгээр бусад нэмэлт өөрчлөлт оруулахаар тохиролцсоныг тэмдэглэсүгэй. Үүнд:
 - 4.1. 2025 оны 04 сарын 08-ны өдрийн Хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээ (Movables Pledge Agreement)-ний барьцааны зүйлд Компанийн жижиг дунд бизнес эрхлэгч нарт олгосон Эргэлтийн хөрөнгийн зээл болон бусад харилцагч нарт олгосон Эргэлтийн хөрөнгийн зээлийг нэмж барьцаалуулах.
 - 4.2. Улмаар Гэрээний багцын холбогдох хэсэгт заасны дагуу Толгой компанийн хүлээсэн үүргийн гүйцэтгэлийг хугацаанд нь хангах баталгаа болгон барьцаалуулж буй хөрөнгийг нэмэгдүүлэх.
5. Компанийн Санхүүжүүлэгч талтай хийсэн тохиролцоог харгалзан энэ тогтоолын 4-т заасан нэмэлт, өөрчлөлтийг Хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээ (Movables Pledge Agreement)-ний зохих хэсгүүдэд тусгаж, нэмэлт өөрчлөлт оруулахыг Компанид зөвшөөрсүгэй. Энэхүү нэмэлт, өөрчлөлтийг энэ тогтоолын Хавсралт 1А. 2025 оны

04 сарын 08-ны өдрийн Хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах гэрээ (Amendment Agreement in relation to the Movables Pledge Agreement dated 8 April 2025) (цаашид “Нэмэлт барьцааны гэрээ” гэх) -д заасан хувилбараар баталсугай.

6. Ийнхүү Нэмэлт барьцааны гэрээг байгуулж буй нь гагцхүү Компанийн ашиг сонирхлын төлөө үйлдэл бөгөөд Компанийн бизнесийн үйл ажиллагааг өргөтгөх зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэж байгааг тэмдэглэсүгэй.
7. Нэмэлт барьцааны гэрээ, түүнчлэн эдгээртэй дагалдах бусад гэрээ, хэлцлийг холбогдох талуудтай эцэслэн тохиролцож байгуулах, гарын үсэг зурж баталгаажуулах, эдгээртэй холбогдуулан Гэрээний багцад дурдсан шаардлагатай бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх бүрэн эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
8. Нэмэлт барьцааны гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан тус багцад багтаж буй аливаа гэрээ, хэлцэлд дурдсан зөвшөөрөл, хүсэлт, мэдэгдэл болон үүгээр хязгаарлагдахгүйгээр Компанийн нэрийн өмнөөс үйлдвэл зохих аливаа баримт бичгийг үйлдэх, тэдгээрт гарын үсэг зурж баталгаажуулан холбогдох талд хүргүүлэх, хариу хүлээн авах зэрэг бүрэн эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
9. Нэмэлт барьцааны гэрээ болон түүнтэй холбогдуулан байгуулсан бусад гэрээний хэрэгжилт, холбогдох бусад мэдээллийг Компанийн ТУЗ-д тухай бүр тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.

